ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн
2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ДГА-2026/1/НА-СТА-ТЕЗ


Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 77520220 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Ахлах аудитор О.Нарангарав
Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn
Аудитор: Н.Мөнхнасан
Цахим хаяг: munkhnasan.n@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн 3 дугаар байр, Залуучуудын гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2026.04.20 № 1-6/416

Танай ______________-ны № ______________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Дорноговь аймгийн аймгийн ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн ТЕЗ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, заврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолоор "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Хот хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хэрэгжүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах зорилгоор 2023-2028 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбоотой аймгийн Засаг даргын 2025 оны А/01 захирамжаар Дорноговь аймаг 2025 оныг “Аялал жуулчлалыг дэмжих жил” болгон зарласан байна. Үүнтэй холбоотой тайлант оны 5 дугаар сард “Говийн бүсийн зөвлөгөөн”, 9 дүгээр сард “Тэнгэрийн хутагт аялал жуулчлалын фестиваль”ийг тус тус зохион байгуулсан байна.

**Аудитын гол асуудал**

1. Орон нутгийн төсвийн орлого 29.9 тэрбум төгрөгөөр тасарсан байна.
2. Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас худалдан авсан 146.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй.

442505381

3. Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлсэн ТАХ-нд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад дэмжлэг, санхүүжилт олгосон байна.

5. Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, худалдан авсан болон гэрээгээр нийлүүлэгдэж байгаа бараа бүтээгдэхүүн хөрөнгийг хүлээж авсан, хүлээлгэн өгсөн акт, шийдвэр, бүртгэл, ажлын тайлан байхгүй, арга хэмжээг санхүүжүүлэхээр гарсан захирамжийн утга, огноонууд зөрүүтэй, тухайн арга хэмжээ нь зохион байгуулсан эсэх нь тодорхой бус, байгуулж байгаа гэрээний тоо хэмжээ хоорондоо зөрүүтэй гэх анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөгөөр 321 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 138,002.3 сая төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж 99,649.1 сая төгрөгийг зарцуулан, үйл ажиллагааны хэрэгжилт 93.2 хувьтай дүгнэгдсэн байна.

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 72,047,054.97 | 89,044,827.32 |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 34,025,891.13 | 30,555,446.53 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 6,982,173.55 | 9,493,768.86 |
| 4 | 1.1.4 УРЬДЧИЛГАА | 4,289,817.96 | 1,457,224.25 |
| 5 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 9,618,904.32 | 10,339,138.9 |
| 6 | 1.1.6 НӨӨЦИЙН БАРАА | 337,904 | 335,911.5 |
| 7 | 1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 16,792,364 | 36,863,337.27 |
| 8 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 196,225,276.07 | 229,718,399.51 |
| 9 | 1.2.1 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 11,333,892.58 | 12,393,296.59 |
| 10 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 184,891,383.49 | 217,325,102.92 |
| 11 | 1.2.2.02 Биет хөрөнгө | 177,448,128.38 | 210,198,092.31 |
| 12 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 7,443,255.11 | 7,055,490.61 |
| 13 | 1.2.2.04 Бусад хөрөнгө /ТӨҮГ/ | 0.0 | 71,520 |
| 14 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 268,272,331.04 | 318,763,226.83 |
| 15 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | 79,087,538.48 | 118,065,085.64 |
| 16 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 29,175,671.84 | 66,986,534.97 |
| 17 | 2.1.1.03 Өглөг | 27,911,919.98 | 62,140,531.96 |
| 18 | 2.1.1.04 Урьдчилж орсон орлого | 1,263,751.86 | 4,846,003.01 |
| 19 | 2.1.2 УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 49,911,866.64 | 51,078,550.68 |
| 20 | 2.1.2.02 Урт хугацаат зээл | 49,911,866.64 | 51,078,550.68 |
| 21 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 189,184,792.56 | 200,698,141.19 |
| 22 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 189,184,792.56 | 200,698,141.19 |
| 23 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 19,297,397.99 | 19,284,635.28 |
| 24 | 2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 23,166,487.87 | 23,054,413.91 |
| 25 | 2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 888,183.16 | 594,990.7 |
| 26 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | 128,793,907.05 | 141,020,868.51 |
| 27 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 17,038,816.49 | 16,743,232.77 |
| 28 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 268,272,331.04 | 318,763,226.83 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 249,637,579.96 | 207,864,972.74 |
| 2 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 108,739,825.41 | 105,945,819.84 |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | 72,070,824.49 | 70,637,227.82 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | 54,229,038.34 | 62,715,119.75 |
| 5 | 1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -1,226,576.31 | -1,571,918.66 |
| 6 | 1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар | 19,068,362.47 | 9,494,026.73 |
| 7 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 8,195,282.32 | 10,424,347.93 |
| 8 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 28,473,718.59 | 24,884,244.08 |
| 9 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 133,234,709.89 | 101,919,152.9 |
| 10 | 1.1.1.04.2 Хөрөнгийн орлого | 43,875 | 17,291.02 |
| 11 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 6,765,618.25 |
| 12 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 7,663,044.66 | 0.0 |
| 13 | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 174,698,787.5 | 173,709,012.92 |
| 14 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 174,698,787.5 | 173,708,362.38 |
| 15 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 163,716,711.52 | 159,689,128.29 |
| 16 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 27,462,818.38 | 32,257,270.37 |
| 17 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 3,391,944.01 | 4,184,994.39 |
| 18 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,968,682.83 | 14,566,192.17 |
| 19 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 57,551,277.3 | 54,956,201.4 |
| 20 | 1.1.2.01.1.05 Нормативт зардал | 517,195.56 | 1,013,145 |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 1,501,697.33 | 1,590,493.08 |
| 22 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 345,371.51 | 309,833.89 |
| 23 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 41,068,682.67 | 22,659,438.49 |
| 24 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 18,909,041.92 | 28,151,559.5 |
| 25 | 1.1.2.01.2 ХҮҮ | 0.0 | 0.89 |
| 26 | 1.1.2.01.3 ТАТААС | 0.0 | 2,146.03 |
| 27 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,982,075.98 | 14,017,087.17 |
| 28 | 1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 650.55 |
| 29 | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 74,938,792.45 | 34,755,959.81 |
| 30 | 1.2.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.0 | 57,958.68 |
| 31 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 11,693,743.88 | 22,968,835.09 |
| 32 | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | -11,693,743.88 | -22,910,876.41 |
| 33 | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 63,245,048.58 | 11,845,083.41 |

## 2.3 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|
| **1** | **1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **125,668,032.72** | **125,668,032.72** |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -352,068.09 | -352,068.09 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 125,315,964.63 | 125,315,964.63 |
| 4 | 1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -60,507.13 | -60,507.13 |
| 5 | 1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 18,300 | 18,300 |
| 6 | 1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт | 665,986.49 | 665,986.49 |
| 7 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 63,245,048.58 | 63,245,048.58 |
| 8 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 189,184,792.56 | 189,184,792.56 |
| 9 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 189,184,792.56 | 189,184,792.56 |
| 10 | 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -326,651.49 | -326,651.49 |
| 11 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 188,858,141.07 | 188,858,141.07 |
| 12 | 1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 75,374 | 75,374 |
| 13 | 1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | -212,552.59 | -212,552.59 |
| 14 | 1.4 Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 3,357.57 | 3,357.57 |
| 15 | 1.5 Өмчид гарсан өөрчлөлт | 487,520.11 | 487,520.11 |
| 16 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 11,845,083.41 | 11,845,083.41 |
| **17** | **1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **201,056,923.55** | **201,056,923.55** |

## 2.4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 204,570,825.05 | 184,951,166.6 |
| 2 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 108,735,796.13 | 105,945,819.84 |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 72,020,421.05 | 70,637,227.82 |
| 4 | 1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -1,226,576.31 | -1,571,918.66 |
| 5 | 1.1.1.1.03.1.04 ААН-ын орлогын албан татвар | 19,068,362.47 | 9,494,026.73 |
| 6 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 8,241,656.49 | 10,424,347.93 |
| 7 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 28,473,718.59 | 24,884,244.08 |
| 8 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 17,167,845.44 | 14,295,075.29 |
| 9 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 8,426,114.78 | 8,751,271.4 |
| 10 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 2,879,758.37 | 1,837,897.39 |
| 11 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 86,781,005.57 | 79,005,346.77 |
| 12 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 45,884,922.57 | 35,220,084.63 |
| 13 | 1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого | 43,875 | 17,291.02 |

| | | | |
|---|---|---|---|
| 14 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 11,033,343.12 |
| 15 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 40,852,208 | 32,734,628 |
| 16 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 9,054,023.35 | 0.0 |
| 17 | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 160,852,155.91 | 159,359,356.36 |
| 18 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 160,852,155.91 | 159,359,356.36 |
| 19 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 118,864,975.8 | 121,218,162.36 |
| 20 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 34,719,280.5 | 41,707,422.58 |
| 21 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,511,652.34 | 4,258,124.41 |
| 22 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,085,084.65 | 17,277,342.34 |
| 23 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 9,666,796.59 | 11,974,006.97 |
| 24 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал | 449,306.08 | 374,961.32 |
| 25 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 1,549,395.33 | 1,636,867.41 |
| 26 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 351,691.33 | 296,411.68 |
| 27 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 40,641,496.34 | 28,280,672.76 |
| 28 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 10,890,272.64 | 15,412,352.9 |
| 29 | 1.1.1.2.01.3 ТАТААС | 200,000 | 2,146.03 |
| 30 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 41,787,180.11 | 38,139,047.97 |
| 31 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 43,718,669.13 | 25,591,810.24 |
| 32 | 1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 1,918,627.45 | 6,424,296.74 |
| 33 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 30,574,844.49 | 35,482,481.87 |
| 34 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 30,574,844.49 | 35,482,481.87 |
| 35 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 30,574,844.49 | 35,482,481.87 |
| 36 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -28,656,217.04 | -29,058,185.12 |
| 37 | 1.1.3.1 Бусад эх үүсвэр | 9,800 | 0.0 |
| 38 | 1.1.3.4 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 68,014.53 | 3,826.8 |
| 39 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -58,214.53 | -3,826.8 |
| **40** | **1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **15,004,237.56** | **-3,470,201.67** |
| ***41*** | ***1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл*** | ***19,021,653.57*** | ***34,025,891.13*** |
| ***42*** | ***1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл*** | ***34,025,891.13*** | ***30,555,689.46*** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| № | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **179,365,151.3** | **148,999,942.98** |
| 2 | **3.1.01.1.1 Татварын орлого** | **134,165,164** | **105,945,819.84** |
| 3 | 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар | 72,040,114.1 | 70,637,227.82 |
| 4 | 3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар | 57,703,227.2 | 62,715,119.75 |
| 5 | 3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 47,274,879.4 | 53,590,350.83 |
| 6 | 3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого | 3,453,000 | 3,479,689.62 |
| 7 | 3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого | 3,563,100 | 2,409,648.49 |
| 8 | 3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого | 1,253,000 | 1,121,673.62 |
| 9 | 3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого | 2,159,247.8 | 2,113,757.2 |
| 10 | 3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -1,571,918.7 | -1,571,918.66 |
| 11 | 3.1.01.1.1.1.2.01 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -1,571,918.7 | -1,571,918.66 |
| 12 | 3.1.01.1.1.1.4 ААН-ын орлогын албан татвар | 15,908,805.6 | 9,494,026.73 |

| | | | |
|---|---|---|---|
| 13 | 3.1.01.1.1.1.4.01 ААН-ын орлогын албан татвар | 15,908,805.6 | 9,494,026.73 |
| 14 | 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар | 10,768,696 | 10,424,347.93 |
| 15 | 3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 8,542,569 | 8,396,401.6 |
| 16 | 3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар | 30,315 | 30,151.5 |
| 17 | 3.1.01.1.1.3.3 Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 1,764,000 | 1,687,949.03 |
| 18 | 3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар | 431,812 | 309,845.8 |
| 19 | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 51,356,353.9 | 24,884,244.08 |
| 20 | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 18,243,901.6 | 14,295,075.29 |
| 21 | 3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж | 16,954,672 | 13,174,694.49 |
| 22 | 3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 709,412 | 512,026.77 |
| 23 | 3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 579,817.6 | 608,354.03 |
| 24 | 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр | 31,596,000.3 | 8,751,271.4 |
| 25 | 3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр | 5,796,000.3 | 4,273,585.65 |
| 26 | 3.1.01.1.1.8.2.02 Дуудлага худалдаа | 25,800,000 | 4,477,685.75 |
| 27 | 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 1,516,452 | 1,837,897.39 |
| 28 | 3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 436,452 | 491,260.99 |
| 29 | 3.1.01.1.1.8.3.03 Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 1,080,000 | 1,346,636.4 |
| **30** | **3.1.01.1.2 Татварын бус орлого** | **45,199,987.3** | **43,054,123.15** |
| 31 | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого | 11,817,782.7 | 10,302,204.13 |
| 32 | 3.1.01.1.2.1.2 Хүүгийн орлого | 506,047.2 | 0.0 |
| 33 | 3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого | 6,419,184.9 | 6,118,396.66 |
| 34 | 3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 790,675.5 | 1,050,817.22 |
| 35 | 3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 461,575.5 | 560,618.17 |
| 36 | 3.1.01.1.2.1.6 Түрээсийн орлого | 60,000 | 152,611.26 |
| 37 | 3.1.01.1.2.1.9 Бусад орлого | 3,580,299.6 | 2,419,760.8 |
| 38 | 3.1.01.1.2.2 Хөрөнгийн орлого | 20,000 | 17,291.02 |
| 39 | 3.1.01.1.2.2.1 Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 20,000 | 17,291.02 |
| 40 | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 33,362,204.6 | 32,734,628 |
| 41 | 3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 33,362,204.6 | 32,734,628 |
| **42** | **3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **188,966,926.4** | **140,023,149.41** |
| **43** | **3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ** | **138,509,720.5** | **108,341,607.95** |
| **44** | **3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **85,567,004.5** | **74,063,750.77** |
| 45 | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 31,791,479.7 | 30,844,201.58 |
| 51 | 3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 4,046,857.8 | 3,762,479.17 |
| 57 | 3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,337,249.1 | 14,510,018 |
| 62 | 3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал | 1,608,723.7 | 1,313,803.18 |
| 69 | 3.1.01.2.1.1.5 Нормативт зардал | 480,200.7 | 326,144.96 |
| 72 | 3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал | 2,070,178.5 | 1,804,214.64 |
| 77 | 3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал | 336,714.2 | 256,771.78 |
| 80 | 3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21,614,706.4 | 15,955,900.43 |
| 88 | 3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал | 8,280,894.4 | 5,290,217.04 |
| 89 | 3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал | 8,157,798.6 | 5,212,563.69 |
| **94** | **3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **52,742,716** | **34,277,857.17** |
| 95 | 3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг | 50,948,071.2 | 33,375,332.11 |
| 96 | 3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг | 50,948,071.2 | 33,375,332.11 |
| 97 | 3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг | 1,794,644.8 | 902,525.07 |
| 98 | 3.1.01.2.1.4.2.02 Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 146,400 | 80,790 |
| 99 | 3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 964,454.4 | 368,803.36 |
| 100 | 3.1.01.2.1.4.2.06 Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 196,587.2 | 179,967.87 |

| | | | |
|---|---|---|---|
| 101 | 3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 297,867.5 | 163,695 |
| 102 | 3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 189,335.7 | 109,268.84 |
| 103 | 3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 49,951,158.5 | 31,681,541.46 |
| 104 | 3.1.01.2.2.2 Их засвар | 3,389,669.8 | 2,177,068.84 |
| 105 | 3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө | 46,561,488.7 | 29,504,472.62 |
| 108 | 3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | -9,601,775.1 | 8,976,793.57 |
| 109 | 3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 9,601,775.1 | -8,976,793.57 |
| 110 | 3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 9,601,775.1 | -8,976,793.57 |
| **111** | **4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.0** | **11,342,773.63** |
| **112** | **5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.0** | **20,677,376.47** |

## 2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **10,348,804.23** | **-10,348,804.23** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **10,348,804.23** | **-10,348,804.23** |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,569.06 | -1,569.06 |
| 350013 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 315,000.00 | -315,000.00 |
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,279,420.29 | -7,279,420.29 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 2,752,814.89 | -2,752,814.89 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **9,332,303.97** | **-9,332,303.97** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 9,332,303.97 | -9,332,303.97 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 9,325,233.97 | -9,325,233.97 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 9,878.71 | -9,878.71 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 118.34 | -118.34 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7,842.50 | -7,842.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 165,773.60 | -165,773.60 |
| 2105 | Норматив зардал | 9,402.46 | -9,402.46 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 67,365.89 | -67,365.89 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,240.00 | -17,240.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 8,175,221.46 | -8,175,221.46 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 872,391.02 | -872,391.02 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,070.00 | -7,070.00 |
| 3 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | -1,016,500.26 | 1,016,500.26 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **500.00** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **500.00** | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дорноговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 40 төсвийн байгууллага, 14 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 30 тусгай сан, 14 төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлан, нийт 98 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 98 байгууллага аудитад хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 48 байгууллагыг түүвэрт хамруулж, 50 байгууллагад дүгнэлт гаргаж "Өөрчлөлтгүй" 36, "Өөрчлөлттэй" 13, "Сөрөг" 1 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад санхүүгийн тайлангийн аудитаар нийт 96,759.2 сая төгрөгийн 358 алдаа, зөрчил илрүүлснээс 93,053,6 сая төгрөгийн 213 алдааг залруулж, 102.6 сая төгрөгийн зөрчилд 22 төлбөрийн акт тогтоож, 1,443.2 сая төгрөгийн зөрчилд 68 албан шаардлага, 2,159.7 сая төгрөгийн зөрчилд 49 зөвлөмж, хариуцлага тооцуулах 6 албан шаардлага хүргүүлсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагууд, төсөв захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,175.8 сая төгрөгийн 150 зөрчил илэрснээс нийцлийн аудиттай холбоотой 2,035.4 сая төгрөгийн зөрчлийг хасаж санхүүгийн тайлангийн аудитад хамаарах 2,140.4 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага байх тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт өгөв

*Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар*
Аудитаар нийт 4,206.1 сая төгрөгийн 18 алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 4,206.1 сая төгрөгийн 13 алдааг залруулж, 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг хүргүүлсэн байна.11 төсвийн төвлөрүүлэн захирагчид өөрчлөлтгүй дүгнэлт, 3 өөрчлөлттэй дүгнэлт өгсөн байна.

*Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар*
Харьяа төсвийн шууд захирагчийн 40 байгууллагаас 15 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 25 дүгнэлт өгсөн байна. Үүнээс: өөрчлөлтгүй 16, өөрчлөлттэй 9 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 26,621.6 сая төгрөгийн 211 алдаа, зөрчил илрүүлснээс 25,913.7 сая төгрөгийн 115 алдааг залруулж, 71.6 сая төгрөгийн зөрчилд 17 төлбөрийн акт тогтоож, 539.5 сая төгрөгийн зөрчилд 47 албан шаардлага, 96.7 сая төгрөгийн зөрчилд 31 зөвлөмж, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

*Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар*
Харьяа орон нутгийн өмчит 14 аж ахуйн нэгж байгууллагаас 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 11 байгууллагад дүгнэлт өгсөн байна. Үүнээс "Өөрчлөлтгүй" 9, "Өөрчлөлттэй" 1, "Сөрөг" 1 дүгнэлтийг хүргүүлсэн байна.

Аудитаар нийт 2,514.6 сая төгрөгийн 42 алдаа, зөрчил илрүүлснээс 2,054.9 сая төгрөгийн 13 алдааг залруулж, 29.9 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 377.7 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага, 52.0 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж, хариуцлага тооцуулах 5 албан шаардлага хүргүүлсэн.

*Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар*
Харьяа 30 сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитаар нийт 63,416.9 сая төгрөгийн 87 алдаа, зөрчил илрүүлснээс 60,878.9 сая төгрөгийн 72 алдааг залруулж, 1.1 сая төгрөгийн зөрчилд 1төлбөрийн акт, 525.9 сая төгрөгийн зөрчилд 13 албан шаардлага, 2,011.0 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

*Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар*

Аудитаар нийт 1,266.4 сая төгрөгийн 1 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд 2 сумын аудиталсан тайланг зөрүүтэй тайлагнаснаас, мөн Засаг даргын тайланд түншлэл-хөгжлийн зээлийн эргэн төлөлтийг буруу бүртгэснээс нэгтгэл тайланг нийт 1.266.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитаар нийт 470.3 сая төгрөгийн 5 зөрчил илрүүлж, 346.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 124.1 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Албан шаардлага

1. Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас худалдан авсан 146.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй.
2. Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлсэн 199.8 сая төгрөгийн ТАХ-нд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

### 3.2 Зөвлөмж

1. <u>*Илрүүлэлт*</u>: Аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 145,064.3 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 115,175.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн, орлогын биелэлт 29,888.7 сая төгрөгөөр тасарч, төлөвлөгөө 79.4 хувиар хэрэгжсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д бүх шатны төсөв захирагч *“хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”* үүрэгтэй гэж заасантай нийцэхгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>:

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тооцоолол судалгаанд үндэслэн боловсруулж, биелэлтийг бүрэн хангаж ажиллах

2. <u>*Илрүүлэлт*</u>: Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудад нийт 24.9 сая төгрөгийн дэмжлэг, санхүүжилт олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д *“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно”,* Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т *“Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэхийг хориглоно”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>:

Төсвийн хөрөнгөөр төрийн бус байгууллагад дэмжлэг, санхүүжилт олгохгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

3. <u>*Илрүүлэлт*</u>: Ажил гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, худалдан авсан болон гэрээгээр нийлүүлэгдэж байгаа бараа бүтээгдэхүүн хөрөнгийг хүлээж авсан, хүлээлгэн өгсөн акт, шийдвэр, бүртгэл, ажлын тайлан байхгүй, арга хэмжээг санхүүжүүлэхээр гарсан захирамжийн утга, огноонууд зөрүүтэй, тухайн арга хэмжээ нь зохион байгуулсан эсэх нь тодохой бус, байгуулж байгаа гэрээний тоо хэмжээ хоорондоо зөрүүтэй гэх анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “*Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна*”, 13.6 ”*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*”, 13.7 “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “*Ерөнхий нягтлан бодогч дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах үүрэгтэй*” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Зарцуулах шийдвэр, худалдан худалдан авах гэрээний тоо хэмжээ, хугацаа, мөнгөн дүнг хянан баталгаажуулах, төлбөр тооцоог хүчин төгөлдөр анхан шатны баримтад үндэслэн хийж гүйцэтгэх, бараа материал, хөрөнгийг орлого, зарлагын баримт хөтлөх, тайлан гаргах, хүлээлцсэн акт үйлдэх, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор
Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Дорноговь аймгийн ТЕЗ | 1 | 1,266,427.4 | | | 1 | 1,266,427.4 | 1 | 1,266,427.4 | | | | |
| 2 | Аймгийн засаг даргын тамгын газар | 3 | 872,216.2 | 1 | 276.5 | 2 | 871,939.7 | 3 | 872,216.2 | | | | |
| 3 | Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал | 2 | 13,335.5 | 1 | 3.2 | 1 | 13,332.3 | 2 | 13,335.5 | | | | |
| 4 | Аймгийн ОНХСан | 3 | 52,826,299.8 | | | 3 | 52,826,299.8 | 3 | 52,826,299.8 | | | | |
| 5 | Айраг сумын Засаг дарга | 1 | 172,992.8 | | | 1 | 172,992.8 | 1 | 172,992.8 | | | | |
| 6 | Айраг сумын ЗДТГ | 5 | 816,804.2 | 3 | 315.9 | 2 | 816,488.3 | 5 | 816,804.2 | | | | |
| 7 | Айраг сумын ИТХ | 4 | 9,729.4 | 1 | 4.4 | 3 | 9,725.1 | 4 | 9,729.4 | | | | |
| 8 | Айраг сумын ОНХС | 2 | 314,190.4 | 1 | 26.1 | 1 | 314,164.3 | 2 | 314,190.4 | | | | |
| 9 | Айраг сумын ХХС | 2 | 488.2 | 1 | 167.9 | 1 | 320.3 | 2 | 488.2 | | | | |
| 10 | Алтанширээ сумын Засаг дарга | 1 | 225,216.7 | | | 1 | 225,216.7 | 1 | 225,216.7 | | | | |
| 11 | Алтанширээ сумын ЗДТГ | 5 | 182,794.6 | 3 | 112.5 | 2 | 182,682.1 | 5 | 182,794.6 | | | | |
| 12 | Алтанширээ сумын ИТХ | 1 | 36,876.8 | 1 | 36,876.8 | | | 1 | 36,876.8 | | | | |
| 13 | Алтанширээ сумын ХХС | 5 | 29,727.2 | 3 | 12,365.2 | 2 | 17,362.0 | 5 | 29,727.2 | | | | |
| 14 | Алтанширээ сумын ОНХС | 2 | 847,982.4 | | | 2 | 847,982.4 | 2 | 847,982.4 | | | | |
| 15 | Даланжаргалан сумын ЗДТГ | 3 | 175,457.3 | 3 | 175,457.3 | | | 3 | 175,457.3 | | | | |
| 16 | Даланжаргалан сумын ИТХ | 5 | 51,631.5 | 2 | 26,351.7 | 3 | 25,279.8 | 5 | 51,631.5 | | | | |
| 17 | Даланжаргалан сумын ОНХС | 3 | 950,188.2 | 1 | 536,122.2 | 2 | 414,066.0 | 3 | 950,188.2 | | | | |
| 18 | Даланжаргалан сумын ХХС | 3 | 69,444.7 | 2 | 56,123.3 | 1 | 13,321.4 | 3 | 69,444.7 | | | | |
| 19 | Дэлгэрэх сумын Засаг дарга | 1 | 151,317.7 | | | 1 | 151,317.7 | 1 | 151,317.7 | | | | |
| 20 | Дэлгэрэх сумын ЗДТГ | 3 | 431,928.8 | 1 | 259.9 | 2 | 431,668.9 | 3 | 431,928.8 | | | | |
| 21 | Дэлгэрэх сумын ХХС | 5 | 10,918.1 | 2 | 52.9 | 3 | 10,865.2 | 5 | 10,918.1 | | | | |
| 22 | Дэлгэрэх сумын ОНХС | 1 | 51,076.2 | | | 1 | 51,076.2 | 1 | 51,076.2 | | | | |
| 23 | Иххэт сумын Засаг дарга | 2 | 600,871.8 | 1 | 256,112.1 | 1 | 344,759.7 | 2 | 600,871.8 | | | | |
| 24 | Иххэт сумын ЗДТГ | 3 | 5,515.3 | 1 | 125.6 | 2 | 5,389.7 | 3 | 5,515.3 | | | | |
| 25 | Иххэт сумын ИТХ | 4 | 6,731.4 | 2 | 4,366.3 | 2 | 2,365.1 | 4 | 6,731.4 | | | | |
| 26 | Иххэт сумын ОНХС | 3 | 285,480.3 | 1 | 132,125.0 | 2 | 153,355.3 | 3 | 285,480.3 | | | | |
| 27 | Мандах сумын ЗДТГ | 3 | 2,057,621.3 | 1 | 956,213.2 | 2 | 1,101,408.1 | 3 | 2,057,621.3 | | | | |
| 28 | Мандах сумын ИТХ | 2 | 3,447.1 | | | 2 | 3,447.1 | 2 | 3,447.1 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **29** | Мандах сумын ОНХС | **2** | **160,810.2** | 1 | 112,210.0 | 1 | 48,600.2 | 2 | 160,810.2 | | | | |
| **30** | Мандах  сумын ХХС | **1** | **1,844.4** | | | 1 | 1,844.4 | 1 | 1,844.4 | | | | |
| **31** | Өргөн сумын Засаг дарга | **1** | **26,437.3** | 1 | 26,437.3 | | | 1 | 26,437.3 | | | | |
| **32** | Өргөн сумын ЗДТГ | **4** | **37,989.3** | 2 | 18,125.1 | 2 | 19,864.2 | 4 | 37,989.3 | | | | |
| **33** | Өргөн сумын ИТХ | **2** | **30,732.8** | 1 | 10,123.5 | 1 | 20,609.3 | 2 | 30,732.8 | | | | |
| **34** | Өргөн сумын ОНХС | **3** | **249,668.6** | 1 | 125,121.1 | 2 | 124,547.5 | 3 | 249,668.6 | | | | |
| **35** | Өргөн сумын ХХС | **1** | **2,965.8** | | | 1 | 2,965.8 | 1 | 2,965.8 | | | | |
| **36** | Сайхандулаан сумын Засаг дарга | **2** | **76,547.3** | 1 | 21,112.3 | 1 | 55,435.0 | 2 | 76,547.3 | | | | |
| **37** | Сайхандулаан сумын ЗДТГ | **8** | **193,762.6** | 6 | 98,215.2 | 2 | 95,547.4 | 8 | 193,762.6 | | | | |
| **38** | Сайхандулаан сумын ИТХ | **5** | **17,981.4** | 2 | 5,212.1 | 3 | 12,769.3 | 5 | 17,981.4 | | | | |
| **39** | Сайхандулаан сумын ОНХС | **1** | **168,480.1** | | | 1 | 168,480.1 | 1 | 168,480.1 | | | | |
| **40** | Сайхандулаан сумын ХХС | **6** | **40,405.3** | 2 | 12,356.1 | 4 | 28,049.2 | 6 | 40,405.3 | | | | |
| **41** | Улаанбадрах сумын Засаг дарга | **1** | **217,447.6** | | | 1 | 217,447.6 | 1 | 217,447.6 | | | | |
| **42** | Улаанбадрах сумын ЗДТГ | **3** | **462,432.8** | | | 3 | 462,432.8 | 3 | 462,432.8 | | | | |
| **43** | Улаанбадрах сумын ИТХ | **2** | **3,105.5** | 1 | 1,205.6 | 1 | 1,899.9 | 2 | 3,105.5 | | | | |
| **44** | Улаанбадрах сумын ОНХС | **2** | **772,132.8** | | | 2 | 772,132.8 | 2 | 772,132.8 | | | | |
| **45** | Улаанбадрах сумын ХХС | **2** | **21,387.7** | | | 2 | 21,387.7 | 2 | 21,387.7 | | | | |
| **46** | Хатанбулаг сумын Засаг дарга | **1** | **1,423,800.0** | | | 1 | 1,423,800.0 | 1 | 1,423,800.0 | | | | |
| **47** | Хатанбулаг сумын ЗДТГ | **2** | **5,009,843.1** | | | 2 | 5,009,843.1 | 2 | 5,009,843.1 | | | | |
| **48** | Хатанбулаг сумын ИТХ | **2** | **346,085.7** | 2 | 346,085.7 | | | 2 | 346,085.7 | | | | |
| **49** | Хатанбулаг сумын ОНХС | **2** | **1,037,967.7** | | | 2 | 1,037,967.7 | 2 | 1,037,967.7 | | | | |
| **50** | Хатанбулаг сумын ХХС | **3** | **1,908.7** | 1 | 165.6 | 2 | 1,743.1 | 3 | 1,908.7 | | | | |
| **51** | Хөвсгөл сумын Засаг дарга | **1** | **27,348.6** | | | 1 | 27,348.6 | 1 | 27,348.6 | | | | |
| **52** | Хөвсгөл сумын ЗДТГ | **3** | **68,028.8** | 1 | 36,012.5 | 2 | 32,016.3 | 3 | 68,028.8 | | | | |
| **53** | Хөвсгөл ИТХ | **3** | **25,574.3** | 3 | 25,574.3 | | | 3 | 25,574.3 | | | | |
| **54** | Хөвсгөл сумын ОНХС | **2** | **28,709.1** | | | 2 | 28,709.1 | 2 | 28,709.1 | | | | |
| **55** | Хөвсгөл сумын ХХС | **4** | **14,791.8** | | | 4 | 14,791.8 | 4 | 14,791.8 | | | | |
| **56** | Эрдэнэ сумын ЗДТГ | **5** | **192,466.1** | 5 | 192,466.1 | | | 5 | 192,466.1 | | | | |
| **57** | Эрдэнэ сумын ИТХ | **3** | **2,387.7** | | | 3 | 2,387.7 | 3 | 2,387.7 | | | | |
| **58** | Эрдэнэ сумын ОНХС | **1** | **300,763.0** | | | 1 | 300,763.0 | 1 | 300,763.0 | | | | |
| **59** | Эрдэнэ сумын ХХС | **4** | **63,214.1** | 4 | 63,214.1 | | | 4 | 63,214.1 | | | | |
| **60** | Сайншанд сумын Засаг дарга | **2** | **1,284,092.1** | | | 2 | 1,284,092.1 | 2 | 1,284,092.1 | | | | |
| **61** | Сайншанд сумын ЗДТГ | **2** | **86,199.6** | 1 | 21,154.2 | 1 | 65,045.4 | 2 | 86,199.6 | | | | |
| **62** | Сайншанд сумын ИТХ | **4** | **27,008.0** | 1 | 12,300.5 | 3 | 14,707.5 | 4 | 27,008.0 | | | | |
| **63** | Сайншанд сумын ОНХС | **3** | **740,095.0** | 1 | 256,215.3 | 2 | 483,879.7 | 3 | 740,095.0 | | | | |
| **64** | Сайншанд сумын ХХС | **3** | **1,875,096.5** | 1 | 859,000.1 | 2 | 1,016,096.4 | 3 | 1,875,096.5 | | | | |
| **65** | Сайншанд сумын ЗАА | **2** | **828,060.6** | | | 2 | 828,060.6 | 2 | 828,060.6 | | | | |
| **66** | Сайншанд сумын Тохижилт үйлчилгээ | **3** | **12,019,251.6** | 3 | 12,019,251.6 | | | 3 | 12,019,251.6 | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **67** | Сайншанд сумын Зүүнбаян ЗАА | **3** | **171,471.0** | 1 | 86,256.2 | 2 | 85,214.8 | 3 | 171,471.0 | | | | |
| **68** | Сайншанд сумын Зүүнбаян багийн Тохижилт | **1** | **13,323.9** | | | 1 | 13,323.9 | 1 | 13,323.9 | | | | |
| **69** | Замын-Үүд сумын ЗДТГ | **4** | **467,015.3** | 2 | 247,124.2 | 2 | 219,891.1 | 4 | 467,015.3 | | | | |
| **70** | Замын-Үүд сумын ИТХ | **1** | **23,245.4** | | 11,251.1 | 1 | 11,994.3 | 1 | 23,245.4 | | | | |
| **71** | Замын-Үүд сумын ЗАА | **2** | **139,537.4** | 1 | 123,562.1 | 1 | 15,975.3 | 2 | 139,537.4 | | | | |
| **72** | Замын-Үүд сумын ХХС | **3** | **12,862.5** | 2 | 12,000.0 | 1 | 862.5 | 3 | 12,862.5 | | | | |
| **73** | Борхойннаран ЗГБХН | **4** | **32,251.4** | 3 | 23,514.1 | 1 | 8,737.3 | 4 | 32,251.4 | | | | |
| **74** | Мишээлтмана ӨЭМТ Нөхөрлөл /ЗБН/ | **4** | **910,937.4** | 2 | 787,375.0 | 2 | 123,562.4 | 4 | 910,937.4 | | | | |
| **75** | Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба | **2** | **2,303.5** | | | 2 | 2,303.5 | 2 | 2,303.5 | | | | |
| **76** | Орон нутгийн өмчийн газар | **2** | **962,700.0** | 1 | 123,562.1 | 1 | 839,137.9 | 2 | 962,700.0 | | | | |
| **77** | Байгаль орчны газар | **2** | **78,910.3** | | | 2 | 78,910.3 | 2 | 78,910.3 | | | | |
| **78** | Нийтлэг үйлчилгээний газар | **2** | **40,227.6** | | | 2 | 40,227.6 | 2 | 40,227.6 | | | | |
| **79** | Говь консалтинг менежмент ОНӨААТҮГ | **3** | **1,077,595.1** | 1 | 77,596.0 | 2 | 999,999.1 | 3 | 1,077,595.1 | | | | |
| **80** | Их говийн хөгжлийн гарц ОНӨААТҮГ | **1** | **58.3** | | | 1 | 58.3 | 1 | 58.3 | | | | |
| **81** | Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ | **1** | **34,110.2** | | | 1 | 34,110.2 | 1 | 34,110.2 | | | | |
| **Нийт дүн** | | **214** | **94,320,084.3** | **86** | **17,947,257.1** | **128** | **76,372,827.2** | **214** | **94,320,084.3** | - | - | - | - |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Д/д | Байгууллагын нэр | *Нийт зөрчил* | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Зөвлөмж | | Албан шаардлага | | Төлбөрийн акт | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | *Тоо* | *Дүн* | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | АШ тоо | Тоо | Дүн |
| 1 | Дорноговь аймгийн ТЕЗ | ***5*** | ***470,262.6*** | 3 | 124,172.3 | 2 | 346,090.3 | | - | | | | |
| 2 | Аймгийн засаг даргын тамгын газар | ***3*** | ***66,422.5*** | - | - | 3 | 66,422.5 | | - | | | | |
| 3 | Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал | ***3*** | ***154,358.9*** | - | - | 3 | 154,358.9 | | - | | | | |
| 4 | Айраг сумын ЗДТГ | ***3*** | ***23,505.1*** | 1 | - | 1 | 1,505.5 | 1 | 21,999.6 | | | | |
| 5 | Айраг сумын ИТХ | ***2*** | ***5,302.7*** | 1 | 2,330.0 | 1 | 2,972.7 | | - | | | | |
| 6 | Алтанширээ сумын ЗДТГ | ***2*** | ***-*** | 2 | - | | - | | - | | | | |
| 7 | Алтанширээ сумын ОНХС | ***3*** | ***148,607.8*** | | - | 3 | 148,607.8 | | - | | | | |
| 8 | Алтанширээ сумын ХХС | ***1*** | ***-*** | | - | 1 | - | | - | | | | |
| 9 | Даланжаргалан сумын  Засаг дарга | ***1*** | | 1 | - | | - | | - | | | | |
| 10 | Даланжаргалан сумын ЗДТГ | ***5*** | ***37,008.2*** | | - | 5 | 37,008.2 | | - | | | | |
| 11 | Даланжаргалан сумын ИТХ | ***1*** | ***100.0*** | | - | | - | 1 | 100.0 | | | | |
| 12 | Даланжаргалан сумын ОНХС | ***1*** | ***11,331.2*** | | - | 1 | 11,331.2 | | - | | | | |
| 13 | Дэлгэрэх сумын ЗДТГ | ***4*** | ***8,807.4*** | 2 | 1,692.0 | 1 | 6,360.0 | 1 | 755.3 | | | | |
| 14 | Иххэт сумын ЗДТГ | ***4*** | ***25,185.8*** | 2 | - | 1 | 1,000.0 | 1 | 24,185.8 | | | | |
| 15 | Иххэт сумын ИТХ | ***1*** | ***8,800.0*** | 1 | 8,800.0 | | - | | - | | | | |
| 16 | Мандах сумын Засаг дарга | ***2*** | ***4,177.5*** | | - | 2 | 4,177.5 | | - | | | | |
| 17 | Өргөн сумын Засаг дарга | ***1*** | ***-*** | 1 | - | | - | | - | | | | |
| 18 | Сайхандулаан сумын ЗДТГ | ***7*** | ***7,037.2*** | 3 | 900.7 | 4 | 6,136.5 | | - | | | | |
| 19 | Сайхандулаан сумын ИТХ | ***3*** | ***3,559.9*** | 2 | - | 1 | 3,559.9 | | - | | | | |
| 20 | Сайхандулаан сумын ОНХС | ***1*** | ***1,111.3*** | | - | | - | 1 | 1,111.3 | | | | |
| 21 | Улаанбадрах сумын ОНХС | ***2*** | ***18,000.0*** | | - | 2 | 18,000.0 | | - | | | | |
| 22 | Улаанбадрах сумын ХХС | ***1*** | ***1,612.2*** | | - | 1 | 1,612.2 | | - | | | | |
| 23 | Хатанбулаг сумын Засаг дарга | ***1*** | ***-*** | | - | 1 | - | | - | | | | |
| 24 | Хатанбулаг сумын ЗДТГ | ***8*** | ***184,715.8*** | 1 | 43,396.0 | 6 | 141,319.8 | | - | 1 | | | |
| 25 | Хатанбулаг сумын ИТХ | ***5*** | ***31,238.3*** | 2 | 317.0 | 3 | 30,921.3 | | - | | | | |
| 26 | Хатанбулаг сумын ХХС | ***1*** | ***54,159.2*** | | - | 1 | 54,159.2 | | - | | | | |
| 27 | Хөвсгөл сумын ЗДТГ | ***7*** | ***15,486.8*** | 2 | - | 3 | 12,404.3 | 2 | 3,082.5 | | | | |
| 28 | Хөвсгөл сумын ИТХ | ***2*** | ***526.4*** | | - | | - | 2 | 526.4 | | | | |
| 29 | Хөвсгөл сумын ОНХС | ***2*** | ***257,515.1*** | | - | 2 | 257,515.1 | | - | | | | |
| 30 | Хөвсгөл сумын ХХС | ***1*** | ***34,698.5*** | | - | 1 | 34,698.5 | | - | | | | |
| 31 | Эрдэнэ сумын ЗДТГ | ***3*** | ***20,851.9*** | 1 | - | 2 | 20,851.9 | | - | | | | |
| 32 | Эрдэнэ сумын ОНХС | ***2*** | ***2,011,025.6*** | 1 | 2,011,025.6 | 1 | - | | - | | | | |
| 33 | Сайншанд сумын Засаг дарга | ***1*** | ***-*** | 1 | - | | - | | - | | | | |
| 34 | Сайншанд сумын ЗДТГ | ***11*** | ***59,967.7*** | 1 | 9,950.0 | 6 | 34,389.7 | 4 | 15,628.0 | | | | |
| 35 | Сайншанд сумын ЗАА | ***3*** | ***-*** | 2 | - | 1 | - | | - | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **36** | Сайншанд сумын Тохижилт үйлчилгээний газар | ***1*** | ***-*** | 1 | - | | - | | - | | | | |
| **37** | Сайншанд сумын Зүүнбаян багийн ЗАА | ***3*** | ***529.2*** | 1 | 529.2 | 2 | - | | - | | | | |
| **38** | Сайншанд сумын Зүүнбаян багийн Тохижилт | ***1*** | ***-*** | 1 | - | | - | | - | | | | |
| **39** | Замын-Үүд сумын Засаг дарга | ***1*** | ***-*** | 1 | - | | - | | - | | | | |
| **40** | Замын-Үүд сумын ЗДТГ | ***2*** | ***39,733.8*** | 1 | 28,008.8 | 1 | 11,725.0 | | - | | | | |
| **41** | Замын-Үүд сумын ЗАА | ***1*** | ***-*** | 1 | - | | - | | - | | | | |
| **42** | Замын-Үүд сумын НААҮ ОНӨААТҮГ | ***9*** | ***287,843.4*** | 4 | 473.0 | 3 | 287,370.4 | | - | 2 | | | |
| **43** | Агатова ӨЭМТ Нөхөрлөл /ЗБН/ | ***1*** | ***1,260.0*** | 1 | 1,260.0 | | - | | - | | | | |
| **44** | Мишээлтмана ӨЭМТ Нөхөрлөл /ЗБН/ | ***1*** | ***4,900.0*** | 1 | 4,900.0 | | - | | - | | | | |
| **45** | Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба | ***6*** | ***6,121.6*** | 1 | 792.0 | | - | 5 | 5,329.6 | | | | |
| **46** | Байгаль орчны газар | ***2*** | ***4,409.7*** | 1 | - | 1 | 4,409.7 | | - | | | | |
| **47** | Нийтлэг үйлчилгээ | ***1*** | ***-*** | 1 | - | | - | | - | | | | |
| **48** | Говь консалтинг менежмент ОНӨААТҮГ | ***5*** | ***26,688.4*** | 1 | 1,170.0 | 2 | 24,385.4 | 2 | 1,133.0 | | | | |
| **49** | Дагшин-Эрдэнэ ОНӨААТҮГ | ***3*** | ***-*** | 1 | - | | - | | - | 2 | | | |
| **50** | Дорноговь Орон сууц ОНӨААТҮГ | ***3*** | ***72,980.3*** | 1 | 44,200.0 | | - | 2 | 28,780.3 | | | | |
| **51** | Хамарын хийдийн тусгай хамгаалалттай газрын захиргаа ОНӨААТҮГ | ***2*** | ***252.4*** | 1 | - | 1 | 252.4 | | - | | | | |
| **52** | Чандмань-Илч ХХК | ***5*** | ***65,742.5*** | 3 | - | 1 | 65,742.5 | | - | 1 | | | |
| **Нийт дүн** | | ***150*** | ***4,175,836.6*** | ***52*** | ***2,283,916.5*** | ***70*** | ***1,789,288.2*** | ***22*** | ***102,631.9*** | ***6*** | ***0*** | ***0*** | ***0*** |